



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/287


Ховд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын
бүтэц, орон тоог батлах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2021 оны А/63 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.
2. Тус газрын хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагааг батлагдсан бүтэц орон тоо, цалингийн санд багтаан зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/515 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

Бүтцийн нэгж	Албан тушаалын нэр	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
Газрын дарга		T3-10	1
Захиргаа аж ахуйн алба	Албаны дарга /Хөдөө аж ахуйн ололт нэвтрүүлэлт, хамтын ажиллагаа хариуцна/	T3-7	1
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Ахлах нягтлан бодогч	TY-8	1
	Техник хэрэгсэл, программ сүлжээ, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	TY-7	1
	Архив, бичиг хэрэг няравын ажил хариуцсан мэргэжилтэн	TY-5	1
	Жолооч	TY-3	1
	Үйлчлэгч	TY-1	1
	Харуул хамгаалагч	TY-1	3
	Бүгд		
Мал үржлийн алба	Албаны дарга, Ерөнхий мал зүйч /Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, технологийн хяналтын асуудал хариуцна/	T3-7	1
	Малын генетик нөөцийн ашиглалт, эрчимжүүлэлт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн асуудал, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Малын удам зүйн үнэлгээ, цөм сүрэг, үүлдэр, ашиг шимийн сайжруулалт, үржүүлэг технологийн ажил үйлчилгээ, итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, ялган тэмдэглэгээ хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Бүгд		
Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний алба	Албаны дарга /Хөнгөн болон жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуй үйлчилгээний асуудал хариуцна/	T3-7	1
	Газар тариалангийн үйлдвэрлэл, техник, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-5	1
	Бүгд		
НИЙТ			20